

**ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН АСУУДЛЫГ БУСАД ОРНЫ ҮНДСЭН ХУУЛЬД ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ (Харьцуулсан судалгаа)**

*Б. Товуусүрэн, Ю. Эрдэнэтуяа, Б. Буяндэлгэр,  
К. Пүрэвсүрэн, Ш. Хишигсүрэн, Б. Хатантуул*

**1. ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН АСУУДЛААРХИ АЗИЙН ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ (Харьцуулсан хүснэгт)**

**1. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС (Ерөнхийлөгчийн засаглалтай)<sup>58</sup>**

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
Батлагдсан: <b>1987.10.29</b> Бүтэц: 10 бүлэг, 130 зүйлтэй.	<b>128 дугаар зүйл</b> (1) Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн олонхи эсхүл Ерөнхийлөгч гаргана.	<b>130 дугаар зүйл</b> (1) Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг нийтэд зарласнаас хойш 60 хоногийн дотор Үндэсний Ассамблей (ҮА) хэлэлцэж, нийт гишүүдийн 2/3-оос доошгүйн саналаар шийдвэрлэнэ. (2) Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг ҮА-аар хэлэлцэж дэмжигдсэнээс хойш 30-аас доошгүй хоногийн дараа ард нийтийн санал асуулга (national referendum) явуулна. Санал асуулгын дүнг Үндэсний ассамблейн сонгуульд оролцох эрх бүхий сонгогчдын олонхийн өгсөн саналаар батална. (3) Энэхүү зүйлийн 2 дэх заалтын дагуу санал асуулгын дүнг хүлээн зөвшөөрснөөр Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт дуусгавар болж, нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг Ерөнхийлөгч нэн даруй гаргана.	<b>128 дугаар зүйл</b> (2) Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг сунгах тухай болон Ерөнхийлөгчийг дахин сонгох тухай Үндсэн хуульд оруулах санал нь уг өөрчлөлтийн тухай санал дэвшүүлэх үед үүргээ гүйцэтгэж буй Ерөнхийлөгчид үл хамаарна. <b>129 дүгээр зүйл</b> Энэхүү өөрчлөлтийг Үндсэн хуульд оруулах тухай саналыг Ерөнхийлөгч олон нийтэд 20-иос доошгүй хоногийн өмнө мэдэгднэ.
<b>ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ SOUTH KOREA - CONSTITUTION</b> { Adopted on: 17 July 1948} { ICL Document Status: 29 Oct 1987 } <a href="http://www.servat.unibe.ch/icl/ks00000.html">http://www.servat.unibe.ch/icl/ks00000.html</a>	Chapter X <b>Amendments to the Constitution</b> <b>Article 128 [Initiative]</b> (1) A proposal to amend the Constitution can be introduced either by a majority of the total members of the National Assembly or by the President.	<b>Article 130 [Majority, Referendum]</b> (1) The National Assembly decides upon the proposed amendments within sixty days of the public announcement, and passage by the National Assembly requires the concurrent vote of two-thirds or more of the total members of the National Assembly. (2) The proposed amendments to the Constitution are submitted to a national referendum not later than thirty days after passage by the National Assembly, and are confirmed by more than one half of all votes cast by more than one half of voters eligible to vote in elections for members of the National Assembly. (3) When the proposed amendments to the Constitution receive the concurrence prescribed in Paragraph (2), the amendments to the Constitution is finalized, and the President promulgates it without delay.	<b>Article 128</b> (2) Amendments to the Constitution for the extension of the term of office of the President or for a change allowing for the re-election of the President are not effective for the President in office at the time of the proposal for such amendments to the Constitution. <b>Article 129 [Publication]</b> Proposed amendments to the Constitution are presented to the public by the President for twenty days or more.

<sup>58</sup> Парламентын нэг танхимтай.

**2. ЯПОН УЛС** (Хязгаарлагдмал бүрэн эрхт хаант засаглалтай.  
Төрийн эрх барих дээд байгууллага нь парламент)<sup>59</sup>

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
Батлагдсан: <b>1946.11.03</b> Хүчин төгөлдөр үйлчилсэн: <b>1947.03.03</b> Батлагдсанаас хойш нэмэлт, өөрчлөлт оруулаагүй. Бүтэц: 11 бүлэг, 103 зүйл.	<b>9 ДҮГЭЭР БҮЛЭГ</b> <b>96 дугаар зүйл</b> Санаачлах эрхийг зөвхөн парламент эдэлнэ. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Төлөөлөгчдийн танхим буюу доод танхим, Зөвлөхүүдийн танхим буюу дээд танхим тус бүрийн гишүүдийн 2/3-оос доошгүйн санал авсан байх шаардлагатай.	<b>96 дугаар зүйл</b> ...Ийнхүү гишүүдийн 2/3-ын саналаар зөвшөөрөгдсөн төслийг ард нийтийн санал асуулга явуулж шийдвэрлэнэ. Санал асуулгад оролцогчдын олонхийн дэмжлэг авсан нэмэлт, өөрчлөлтийг ард түмний нэрийн өмнөөс Эзэн хаан хуульчлах бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн бүрэлдэхүүн хэсэг нь болно.	<b>Тайлбар:</b> Нэмэлт, өөрчлөлт оруулахаар бол Үндсэн хуулийн 9 дүгээр бүлгийн 96 дугаар зүйлд заасан журмыг баримтална. Ард нийтийн санал асуулга хамгийн чухал үндэслэл байхаар зохицуулсан байна. Санал асуулга явуулахгүйгээр Үндсэн хуульд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулахыг хязгаарлажээ.
<b>ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ</b> THE CONSTITUTION OF JAPAN November 3, 1946 <a href="http://www.solon.org/Constitutions/Japan/English/english-Constitution.html">http://www.solon.org/Constitutions/Japan/English/english-Constitution.html</a>	<b>CHAPTER IX: AMENDMENTS</b> <b>Article 96:</b> Amendments to this Constitution shall be initiated by the Diet, through a concurring vote of two-thirds or more of all the members of each House and shall thereupon be submitted to the people for ratification, which shall require the affirmative vote of a majority of all votes cast thereon, at a special referendum or at such election as the Diet shall specify. 2) Amendments when so ratified shall immediately be promulgated by the Emperor in the name of the people, as an integral part of this Constitution.		

\*\*\*

<sup>59</sup> Хязгаарлагдмал бүрэн эрхт хаан - Японы Эзэн хаан нь Үндсэн хуульд заасны дагуу «Бүрэн ард түмнийхээ хүсэл бодлыг илэрхийлэн, төр улс, хүн ардынхаа эв нэгдлийн бэлэг тэмдэг» нь болж байдаг ажээ. Эзэн хаан нь Төрийн тэргүүний хувьд Үндсэн хуулийн дагуу. «парламентаас сонгогдсон Ерөнхий сайдыг томилон батламжлах, Сайд нарын Танхимын саналаар Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг томилох, Парламентын чуулганыг зарлан хуралдуулах, төлөөлөгчдийн танхимыг тараах, бүх нийтийн сонгуулийг зарлах зэрэг гол гол үүргийг гүйцэтгэдэг байна. Түүнчлэн Эзэн хаан төр засгийн хууль, зарлиг, гэрээний батламж зэргийг зарлан тунхаглах, Үндсэн ба бусад хуулийг нийтлэх, засвар оруулах гэх мэтийн үйл ажиллагаанд оролцдог байна.

3. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС (Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал)<sup>60</sup>

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субьект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
<p>Үндсэн хуулиа 4 удаа шинэчлэн баталсан.</p> <p>Баталсан: <b>1982.12.04</b></p> <p>Одоогийн мөрдөж буй Үндсэн хуульд 4 удаа өөрчлөлт оруулсан.</p> <p>Өөрчлөлт оруулсан огноо: <b>1988.04.12, 1993.03.29 1999.03.15</b></p> <p>Бүтэц: 4 бүлэг, 138 зүйлтэй.</p>	<p><b>62 дугаар зүйл</b></p> <p>Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал / БХАТИХ/ дараахь эрхийг хэрэгжүүлнэ:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах</li> <li>2. Үндсэн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих... зэрэг 15 заалттай.</li> </ol> <p><b>67 дугаар зүйл</b></p> <p>БХАТИХ-ын Байнгын хороо дараахь эрхийг хэрэгжүүлнэ:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үндсэн хуульд тайлбар хийж, Үндсэн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих,</li> <li>2. БХАТИХ-аас батлан гаргахаас бусад дүрмийг батлах, өөрчлөлт оруулах</li> <li>3. БХАТИХ-ын чуулганы завсарлагаар БХАТИХ-аас баталсан хууль, тогтоомжийн үндсэн зарчим, үзэл баримтлалыг өөрчлөхгүйгээр шаардлагатай нэмэлт, өөрчлөлт, хавсралтыг батлан гаргах;</li> <li>4. Хуулийн тайлбар гаргах</li> </ol> <p>...</p> <ol style="list-style-type: none"> <li>7. Төрийн Зөвлөлөөс гаргасан зарлиг, захирамж зэрэг захиргааны эрхийн акт нь Үндсэн хуулийн үзэл санаатай үл нийцэхээр бол тэдгээрийг хүчингүй болгох;</li> <li>8. Үндсэн хууль болон төрийн засаг захиргааны шийдвэртэй үл нийцэх муж, өөртөө засах орон, шууд харьяа хотын төрийн эрх бүхий байгууллагын тогтоосон орон нутгийн чанартай тогтоол, шийдвэрийг хүчингүй болгох</li> </ol>	<p><b>64 дүгээр зүйл</b></p> <p>Үндсэн хуульд өөрчлөлт оруулахад БХАТИХ-ын Байнгын хороо, эсхүл БХАТИХ-ын депутатуудын 1/5-ээс доошгүй депутат санаачлан БХАТИХ-ын нийт депутатын 2/3 -оос доошгүйн саналаар батална.</p> <p>Дүрэм, тогтоолыг БХАТИХ-ын нийт депутатын олонхийн саналаар батална.</p>	



UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>60</sup> БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их хурал бол төрийн дээд эрхт байгууллага мөн. Түүний байнгын байгууллага бол Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их хурлын байнгын хороо мөн. (Үндсэн хуулийн 3 дугаар бүлэг, 57 дугаар зүйл)


<p><b>ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ</b></p> <p>CONSTITUTION OF THE PEOPLE'S REPUBLIC OF CHINA</p> <p><b>БНХАУ-ын Хуулийн эмхтгэл, цуврал-1. УБ, 2008 он.</b></p> <p>БНХАУ-ын Үндсэн хууль 5-51 дэх тал.</p> <p>CONSTITUTION OF THE PEOPLE'S REPUBLIC OF CHINA</p> <p>(Adopted on December 4, 1982)</p> <p><a href="http://english.peopledaily.com.cn/constitution/constitution.html">http://english. peopledaily.com. cn/constitution/ constitution.html</a></p>	<p>CHAPTER III. THE STRUCTURE OF THE STATE</p> <p>SECTION 1. THE NATIONAL PEOPLE'S CONGRESS</p> <p><b>Article 62.</b> The National People's Congress exercises the following functions and powers:</p> <p>(1) To amend the Constitution;</p> <p>(2) To supervise the enforcement of the Constitution;</p> <p>...</p> <p><b>Article 67.</b> The Standing Committee of the National People's Congress exercises the following functions and powers:</p> <p>(1) To interpret the Constitution and supervise its enforcement;</p> <p>(2) To enact and amend statutes with the exception of those which should be enacted by the National People's Congress;</p> <p>(3) To enact, when the National People's Congress is not in session, partial supplements and amendments to statutes enacted by the National People's Congress provided that they do not contravene the basic principles of these statutes;</p> <p>(4) To interpret statutes;</p> <p>...</p> <p>(7) To annul those administrative rules and regulations, decisions or orders of the State Council that contravene the Constitution or the statutes;</p> <p>(8) To annul those local regulations or decisions of the organs of state power of provinces, autonomous regions and municipalities directly under the Central Government that contravene the Constitution, the statutes or the administrative rules and regulations;</p> <p>...</p> <p><b>Article 64.</b></p> <p>Amendments to the Constitution are to be proposed by the Standing Committee of the National People's Congress or by more than one-fifth of the deputies to the National People's Congress and adopted by a majority vote of more than two-thirds of all the deputies to the Congress. Statutes and resolutions are adopted by a majority vote of more than one half of all the deputies to the National People's Congress.</p>
---	--

\* \* \*

#### 4. БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС

(Парламентын удирдлагатай Бүгд Найрамдах, нэгдмэл Улс)

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, бо- ловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хяз- гаарлалт, хэлбэр
--	---	----------------------------	--



<p><b>1982.10.18</b>-ны өдөр баталж, <b>1982.10.20</b>-ны өдөр ард нийтийн санал асуулга явуулахаар Төрийн мэдээлэлд нийтэлж, <b>1982.11.07</b>-ны өдрийн хуулиар ард нийтийн саналаар хүлээн зөвшөөрсөнийг баталсан.</p> <p>Өнөөг хүртэл 1987, 1993, 1995, 1999 онд 2 удаа, 2001 онд 2 удаа, 2002, 2004 он нийт 9 удаа тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.</p> <p>Турк Улсын Үндсэн хууль нь эхлэл хэсэг болон 7 хэсэг /хэсэг нь дотроо бүлэгт хуваагдана/, нийт 177 зүйлтэй. Мөн 6 дугаар хэсэгт түр үйлчлэх 16 зүйлтэй.</p>	<p><b>I. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, сонгуульд болон ард нийтийн санал асуулгад оролцох</b></p> <p><b>175 дугаар зүйл</b></p> <p>Үндсэн хуульд өөрчлөлт оруулах саналыг Туркийн Үндэсний Их Хурлын нийт гишүүний хамгийн багадаа 1/3-ээс доошгүй нь бичгээр гаргана.</p>	<p><b>175 дугаар зүйл</b></p> <p>Үндсэн хуулийн өөрчлөлтийн тухай саналыг нэгдсэн чуулганаар хоёр удаа хэлэлцэнэ. Өөрчлөх саналыг нийт гишүүний 3/5-ын нууц санал хураалтаар хүлээн зөвшөөрнө.</p> <p>Ерөнхийлөгч Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэг удаа дахин хэлэлцүүлэхээр Туркийн Үндэсний Их Хуралд буцааж болно. Ийнхүү буцаасан төслийг нийт гишүүний 2/3 буюу түүнээс дээшхийн саналаар дахин хэвээр баталвал Ерөнхийлөгч уг хуулийн төслөөр ард нийтийн санал асуулга явуулж болно.</p> <p>Үндэсний Их Хурлын бүх гишүүний 3/5, эсхүл 2/3-оос доошхийн саналаар баталсан Үндсэн хуулийн өөрчлөлтийн тухай хуулийн төслийг Ерөнхийлөгч Их Хуралд буцаагаагүй тохиолдолд ард нийтийн санал асуулга явуулахаар Төрийн мэдээлэлд нийтлэнэ.</p> <p>Шууд эсхүл Ерөнхийлөгчийн буцааснаар Их Хурлын нийт гишүүний 2/3 буюу түүнээс дээшхийн саналаар баталсан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон төслийн аль нэг зүйлээр Ерөнхийлөгч ард нийтийн санал асуулга явуулж болно. Ард нийтийн санал асуулга явуулахааргүй төсөл, эсхүл холбогдох зүйлийг Төрийн мэдээлэлд нийтлэнэ.</p> <p>Ард нийтийн санал асуулга явуулсан хуулийг мөрдөж эхлэхийн тулд ард нийтийн санал асуулгын хүчин төгөлдөр саналын олонхийн дэмжлэгийг авсан байх шаардлагатай.</p> <p>Үндэсний Их Хурал Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлахдаа энэхүү хуулиар ард нийтийн санал асуулга явуулахад Үндсэн хуулийн өөрчилж буй заалтуудаас алийг хамтад нь, алийг нь тус тусад нь санал хураах талаар шийдвэрлэнэ.</p>	<p><b>IV. Өөрчилж болохгүй зүйл</b></p> <p><b>4 дүгээр зүйл</b></p> <p>Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд заасан Төрийн хэлбэр нь Бүгд найрамдах болох тухай заалт, 2 дугаар зүйлд заасан Бүгд Найрамдахын шинжүүд, болон 3 дугаар зүйлд заасан заалтууд өөрчлөгдөшгүй ба өөрчлөх санал тавьж болохгүй.</p> <p><b>175 дугаар зүйл</b></p> <p>Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай саналыг хэлэлцэх болон батлах нь энэхүү зүйлд зааснаас гадна хууль хэлэлцэх, болон батлах тухай заалтад хамаарна.</p>
---	--	---	--

<p><b>ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ</b></p> <p><b>THE CONSTITUTION OF THE REPUBLIC OF TURKEY</b></p> <p><a href="http://www.anayasa.gov.tr/images/loaded/pdf/dosyalar/theconstitutionoftherepublicofturkey.pdf">http://www.anayasa.gov.tr/images/loaded/pdf/dosyalar/theconstitutionoftherepublicofturkey.pdf</a></p>	<p><b>PART SEVEN FINAL PROVISIONS</b></p> <p><b>I. Amendment of the Constitution, Participation in Elections and Referenda</b></p> <p><b>ARTICLE 175.</b> (As amended on May 17, 1987)</p> <p>The constitutional amendment shall be proposed in writing by at least one-third of the total number of members of the Turkish Grand National Assembly. Proposals to amend the Constitution shall be debated twice in the Plenary Session. The adoption of a proposal for an amendment shall require a three-fifths majority of the total number of members of the Assembly by secret ballot.</p>	<p><b>ARTICLE 175.</b></p> <p>The President of the Republic may refer the laws related to the Constitutional amendments for further consideration. If the Assembly adopts the draft law referred by the President by a two-thirds majority, the President may submit the law to referendum.</p> <p>If a law is adopted by a three-fifths or less than two-thirds majority of the total number of votes of the Assembly and is not referred by the President for further consideration, it shall be published in the Official Gazette and shall be submitted to referendum.</p> <p>A law on the Constitutional amendment adopted by a two-thirds majority of the total number of members of the Turkish Grand National Assembly directly or if referred back by the President for further consideration, or its articles as considered necessary may be submitted to a referendum by the President. Laws or related articles of the Constitutional amendment not submitted to referendum shall be published in the Official Gazette</p> <p>Laws related to Constitutional amendment which are submitted to referendum, shall require the approval of more than half of the valid votes cast.</p> <p>The Turkish Grand National Assembly, in adopting the laws related to the Constitutional amendment, shall also decide on which provisions shall be submitted to referendum together and which shall be submitted individually.</p> <p>Every measure including fines shall be taken to secure participation in referenda, general elections, by-elections and local elections.</p>	<p>IV. Irrevocable Provisions</p> <p><b>ARTICLE 4.</b></p> <p>The provision of Article 1 of the Constitution establishing the form of the state as a Republic, the provisions in Article 2 on the characteristics of the Republic, and the provision of Article 3 shall not be amended, not shall their amendment be proposed.</p> <p><b>ARTICLE 175</b></p> <p>The consideration and adopting of proposals for the amendment of the Constitution shall be subject to the provisions governing the consideration and adoption of legislation, with the exception of the conditions set forth in this article.</p>
--	--	---	---

\* \* \*

**5. БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС**

(Парламентын 2 танхимтай, Парламентын Бүгд Найрамдах Улс)

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
------------------------------------	---	----------------------------	--



<p>Баталсан: <b>1949.11.26</b></p> <p>Нийт 94 удаа нэмэлт, өөрчлөлт орсон.</p> <p>Бүтэц: 22 хэсэг, 395 зүйл, 12 хавсралт, 2 нэмэлт хэсэгтэй</p>	<p><b>20 дугаар хэсэг</b> <b>Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах</b> <b>368 дугаар зүйл</b></p> <p>(2) Хуулийн төсөл нь танхим бүрээр хэлэлцэгдэж, тухайн танхимын гишүүдийн 2/3-ын ирцтэйгээр санал хураалт явуулж, танхимийн нийт гишүүдийн олонхиор зөвшөөрөгдсөн тохиолдолд Парламентын аль нэг танхимаас хуулийн төсөл өргөн барьснаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг өргөн мэдүүлж болно.</p>	<p><b>368 дугаар зүйл</b></p> <p>(2) Хуулийн төслийг Ерөнхийлөгч зөвшөөрснөөр төсөлд тусгасны дагуу Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ба дараахь нөхцлийг хангана. Хэрэв дээрхи өөрчлөлт нь,</p> <p>(a) 54, 55, 73, 162 дугаар заалт, эсхүл 241 дүгээр заалт;</p> <p>(b) V хэсгийн IV бүлэг, VI хэсгийн V бүлэг, эсхүл XI хэсгийн I бүлэг;</p> <p>(c) Долдугаар зүйлд заасан жагсаалтаас аль нэг нь,</p> <p>(d) Парламент дахь Мужуудын төлөөлөл;</p> <p>(e) Энэхүү заалтад өөрчлөлт оруулахаар бол уг хуулийн төслийг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхээс өмнө Мужуудын хууль тогтоогчдын 1/2-ээс доошгүйн саналаар хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой.</p> <p>(4) Энэхүү заалтад орсон Үндсэн хуулийн аливаа өөрчлөлтийн (III хэсэг), 1976 оны Үндсэн хуулийн актын 55 дугаар хэсэг (Дөчин хоёр дахь өөрчлөлт)-ийг мөрдөж эхэлснээс өмнө, эсхүл дараа нь бүх шатны шүүхэд маргаан үүсгэхгүй.</p>	<p><b>368 дугаар зүйл</b></p> <p>(1) Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийнхээ хүрээнд Парламентаас хууль хэлэлцэн батлах дэгийн дагуу Үндсэн хуулийн аливаа заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хүчингүй болгож болно.</p> <p>(3) 13 дугаар заалтын нөхцөл нь энэхүү заалтанд орсон аливаа өөрчлөлтөнд үл хамаарна.</p> <p>(5) Аливаа асуудлыг шийдвэрлэх үүднээс, энэ заалтад заасны дагуу Үндсэн хуулийн зүйл, заалтыг нэмэх, өөрчлөх, эсхүл хүчингүй болгох талаар Парламентад Үндсэн хуулиар олгосон эрхэд ямар нэг хязгаарлалт байхгүй.</p>
<p><b>ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ</b></p> <p>THE CONSTITUTION OF INDIA</p> <p><a href="http://lawmin.nic.in/coi.htm">http://lawmin.nic.in/coi.htm</a></p>	<p><b>AMENDMENT OF THE CONSTITUTION</b> <b>Article 368</b></p> <p>2) An amendment of this Constitution may be initiated only by the introduction of a Bill for the purpose in either House of Parliament, and when the Bill is passed in each House by a majority of the total membership of that House and by a majority of not less than two-thirds of the members of that House present and voting,</p>	<p><b>Article 368</b></p> <p>2) it shall be presented to the President who shall give his assent to the Bill and thereupon the Constitution shall stand amended in accordance with the terms of the Bill: Provided that if such amendment seeks to make any change in—</p> <p>(a) article 54, 55, 73, 162 or article 241, or</p> <p>(b) Chapter IV of Part V, Chapter V of Part VI, or Chapter I of Part XI, or</p> <p>(c) any of the Lists in the Seventh Schedule, or</p> <p>(d) the representation of States in Parliament, or</p> <p>(e) the provisions of this article, the amendment shall also require to be ratified by the Legislatures of not less than one-half of the States by resolutions to that effect passed by those Legislatures before the Bill making provision for such amendment is presented to the President for assent.</p> <p>4) No amendment of this Constitution (including the provisions of Part III) made or purporting to have been made under this article [whether before or after the commencement of section 55 of the Constitution (Fortysecond Amendment) Act, 1976] shall be called in question in any court on any ground.</p>	<p><b>Article 368.</b></p> <p>(1) Notwithstanding anything in this Constitution, Parliament may in exercise of its constituent power amend by way of addition, variation or repeal any provision of this Constitution in accordance with the procedure laid down in this article.</p> <p>(3) Nothing in article 13 shall apply to any amendment made under this article.</p> <p>5) For the removal of doubts, it is hereby declared that there shall be no limitation whatever on the constituent power of Parliament to amend by way of addition, variation or repeal the provisions of this Constitution under this article.</p>

**6. БҮГД НАЙРАМДАХ ИНДОНЕЗ УЛС**  
(Парламентын 2 танхимтай Бүгд Найрамдах Улс)<sup>61</sup>

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
<p><b>1945</b> онд баталсан, <b>1999, 2000, 2001, 2002</b> онд нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p> <p>Бүтэц: 16 бүлэг 37 зүйл болон түр үйлчлэх 3 зүйл, нэмэлт 2 зүйлтэй.</p>	<p><b>Хоёр дугаар бүлэг</b> <b>Ардын Зөвлөлдөх Хурал</b> <b>3 дугаар зүйл</b></p> <p>Ардын Зөвлөлдөх Хурал нь Үндсэн хууль батлах, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй.</p>	<p><b>16 дугаар бүлэг</b> <b>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт</b> <b>37 дугаар зүйл</b></p> <p><b>1/</b> Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Ардын Зөвлөлдөх Хурлын нийт гишүүний 1/3-ээс доошгүйн ирцтэйгээр хуралдсан тохиолдолд өргөн барьж болно.</p> <p><b>2/</b> Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал нь бичгэн хэлбэрээр байх бөгөөд өөрчлөх заалтыг тусган, өөрчлөх шалтгааныг дурдсан байна.</p> <p><b>3/</b> Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахын тулд Ардын Зөвлөлдөх Хурлын нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хүрэлцэн ирсэн байх шаардлагатай.</p> <p><b>4/</b> Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай шийдвэрийг нийт гишүүний 50+1 нь хүлээн зөвшөөрсөнөөр батлан гаргана.</p>	<p><b>37 дугаар зүйл</b> <b>5/</b> Төрийн хэлбэр болох Бүгд Найрамдах Индонез, нэгдмэл Улстай холбоотой зүйлүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй.</p>
<p><b>ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ</b> THE 1945 CONSTITUTION OF THE REPUBLIC OF INDONESIA As amended by the First Amendment of 1999, the Second Amendment of 2000, the Third Amendment of 2001 and the Fourth Amendment of 2002 <a href="http://indonesianembassy.kiev.ua/about/files/fourth_const.pdf">http://indonesianembassy.kiev.ua/about/files/fourth_const.pdf</a></p>	<p><b>Chapter II</b> <b>The People's Consultative Assembly</b> (Majelis Permusyawaratan Rakyat or MPR) <b>Article 3</b> <b>(1)</b> The MPR has the authority to amend and enact the Constitution.</p>	<p><b>Article 37</b> <b>(1)</b> A proposal to amend the Articles of this Constitution may be included in the agenda of an MPR session if it is submitted by at least 1/3 of the total MPR membership. <b>(2)</b> Any proposal to amend the Articles of this Constitution shall be introduced in writing and must clearly state the articles to be amended and the reasons for the amendment. <b>(3)</b> To amend the Articles of this Constitution, the session of the MPR requires at least 2/3 of the total membership of the MPR to be present. <b>(4)</b> Any decision to amend the Articles of this Constitution shall be made with the agreement of at least fifty per cent plus one member of the total membership of the MPR.</p>	<p><b>Article 37</b> <b>(5)</b> Provisions relating to the form of the unitary state of the Republic of Indonesia may not be amended.</p>

\* \* \*

<sup>61</sup> Ардын Зөвлөлдөх Хурал нь Ардын Төлөөлөгчдийн Зөвлөл, Бүсүүдийн Төлөөлөгчдийн Зөвлөлөөс бүрдэнэ.

**2. ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН АСУУДЛААР ЕВРОПЫН ХОЛБООНЫ ЗАРИМ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ** (Харьцуулсан хүснэгт)

**7. БҮГД НАЙРАМДАХ РУМЫН УЛС** /парламентын, нэгдмэл улс/

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
Баталсан: <b>1991.11.21</b> 7 хэсэг, 152 зүйлтэй.	<b>146.1 дугаар зүйл</b> 1. Засгийн газраас санал болгосноор Ерөнхийлөгч 2. нийт депутат, эсхүл Сенатын гишүүдийн 1/4 –ээс доошгүй тооны гишүүд 3. санал өгөх эрхтэй 500 000–гаас доошгүй тооны иргэд санаачилж болно.	<b>147 дугаар зүйл</b> <b>Хянан үзэх ажиллагаа</b> 1. Нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэж Депутатуудын танхим, Сенатын танхим тус бүрийн гишүүдийн 2/3-ын саналаар батална. 2. Хоёр танхим тус тусдаа хэлэлцээд санал нэгдэхгүй тохиолдолд хамтарсан хуралдаан явуулж төслийг хоёр танхимын нийт гишүүдийн 3/4-ын саналаар батална. 3. Төслийг хэлэлцэн баталсанаас хойш 30 хоногийн дотор ард нийтийн санал асуулга явуулж дэмжигдсэн тохиолдолд эцэслэн батална. <b>78 дугаар зүйл</b> <b>Хууль хүчин төгөлдөр болох</b> Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хуульд заасан хугацаанаас, эсхүл "Мониторул Официал ал Ромынизи"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	<b>148 дугаар зүйл</b> <b>Нэмэлт, өөрчлөлтийн хүрээ</b> 1. Румын Улсын үндэсний, тусгаар тогтнол, нэгдмэл ба бүрэн бүтэн байдалтай холбоотой заалт, засаглалын Бүгд найрамдах хэлбэр, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, шүүх эрх мэдлийн бие даасан байдал, улс төрийн олон ургалч үзлийн, төрийн албан ёсны хэлний асуудлаар Үндсэн хуулийн холбогдох заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй. 2. Иргэдийн үндсэн эрх, эрх чөлөө болон баталгааг халах, хязгаарлах үр дагавартай аливаа нэмэлт, өөрчлөлтийг оруулахгүй. 3. Дайн, дайн бүхий болон онц байдлын үед Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
<b>ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ</b>	Часть VI Пересмотр Конституции <b>Статья 146.</b> Инициатива пересмотра 1. С инициативой пересмотра Конституции может выступить Президент Румынии по предложению Правительства, не менее одной четверти числа депутатов или сенаторов, а также не менее 500 000 граждан, обладающих правом голоса.	<b>Статья 147. Процедура пересмотра</b> 1. Проект или предложение о пересмотре должны быть приняты Палатой Депутатов и Сенатом большинством не менее двух третей от числа членов каждой Палаты. 2. Если путем согласительной процедуры согласие не достигнуто, Палата Депутатов и Сенат принимают решение на совместном заседании большинством голосов не менее трех четвертей от числа депутатов и сенаторов. 3. Пересмотр становится окончательным после его одобрения на референдуме, организованном в срок до 30 дней после даты принятия проекта или предложения о пересмотре. <b>Статья 78. Вступление закона в силу</b> Закон публикуется в "Мониторул Официал ал Ромынизи" <b>(7)</b> и вступает в силу в день его опубликования или в день, указанный в его тексте.	<b>Статья 148. Пределы пересмотра</b> 1. Положения настоящей Конституции, касающиеся национального, независимого, единого и неделимого характера румынского государства, республиканской формы правления, территориальной целостности, независимости юстиции, политического плюрализма и официального языка, не могут являться предметом пересмотра. 2. Кроме того, не может производиться никакой пересмотр, если его результатом явится отмена основных прав и свобод граждан или их гарантий. 3. Конституция не может пересматриваться в период военного положения или чрезвычайного положения и во время войны.

## 8. БҮГД НАЙРАМДАХ УНГАР УЛС /парламентын, нэгдмэл улс/

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
Ард нийтийн санал асуулгын дүнд <b>1949.08.18-нд</b> Улсын Их хурал баталсан. 1972, 1989 онд шинэчлэн баталсан. 15 хэсэг, 78 зүйлтэй.	<b>25.1 дүгээр зүйл</b> 1. Ерөнхийлөгч 2. Засгийн газар 3. Улсын Их хурлын Байнгын комиссууд, депутат бүр санаачилах эрхтэй	<b>28. 4)</b> Ард нийтийн санал асуулгыг Ерөнхийлөгч, Засгийн газар, УИХ-ын депутатын 1/3-ийн саналаар, эсхүл санал өгөх эрх бүхий 100000 иргэний санал болгосноор УИХ товлон явуулна. <b>24.3.</b> Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг УИХ-ын депутатуудын 2/3-ын саналаар батална. <b>26.1.</b> Хуулийг Ерөнхийлөгч хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн дотор, эсхүл уг хуулийг нийтлэх асуудлыг хурдавчлах талаар УИХ-ын даргаас тавьсан хүсэлтийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор ёсчилсоноор албан ёсны хэвлэлд нийтлэнэ. <b>2)</b> Хэрэв дээрх хугацаанд Ерөнхийлөгч хууль болон хуулийн зарим хэсэгтэй санал нийлэхгүй бол хуулийг ёсчлохоос өмнө өөрийн саналтай хамт УИХ-д буцаана. <b>3)</b> УИХ дахин хэлэлцэж баталсан хуулийг Ерөнхийлөгч 5 өдрийн дотор ёсчлон нийтэлнэ. <b>6)</b> Ард нийтийн санал асуулга явуулахаар шийдвэрлэсэн хуулийн төсөл олонхийн саналаар дэмжигдсэн тохиолдолд Ерөнхийлөгч ёсчлон батална.	
<b>ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ</b>	<b>25. 1)</b> Право законодательной инициативы принадлежит Президенту Республики, Правительству, всем комиссиям Государственного собрания и любому депутату Государственного собрания.	<b>28.С 4)</b> Всенародное голосование рекомендательного характера может быть назначено Государственным собранием по инициативе Президента Республики, Правительства, одной трети депутатов Государственного собрания, либо 100 000 граждан, обладающих избирательным правом. <b>24.3)</b> Для изменения Конституции, а также принятия отдельных решений, определенных в Конституции, необходимы две трети голосов депутатов Государственного собрания. <b>26. 1)</b> Президент Республики обеспечивает опубликование закона в течение пятнадцати дней со дня его вручения, или же в течение пяти дней - по ходатайству ускорить его опубликование со стороны председателя Государственного собрания. Президент Республики подписывает закон, присланный для опубликования. Закон должен быть опубликован в официальном печатном органе. <b>2)</b> Если Президент Республики не согласен с законом или каким-либо его положением, он до подписания в пределах временного срока, отведенного для обдумывания, обозначенного в <a href="#">абзаце 1</a> , может отослать закон со своими замечаниями Государственному собранию для пересмотра. <b>3)</b> Государственное собрание вновь обсуждает закон и вновь решает вопрос о его принятии. Присланный после этого председателем Государственного собрания закон Президент Республики обязан подписать и опубликовать в течение пяти дней. <b>6)</b> Закон, представленный на народный референдум, Президент Республики подписывает только в том случае, если этот закон одобрен народным референдумом (включен Законом 1997:ЛIX).	

\* \* \*

## 9. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛС /Ерөнхийлөгчийн БНУ/

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
<p>Баталсан: <b>1994.02.17</b> (1996.03.25, 1997.02.28 1997.03.11, 1997.03.20 1998.06.12, 1998.06.17 1998.11.20, 1998.12.11 1999.03.12, 1999.05.07 2000.03.23, 2000.05.16-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан) 9 хэсэг, 8 бүлэг, 198 зүйлтэй</p>	<p><b>195, 198 дугаар зүйл</b> Хууль тогтоогч үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх талаар мэдэгдэл хийх эрхтэй. Хоёр танхимын аль аль нь хэлэлцэн батлах эрхтэй.</p>	<p><b>VIII хэсэг, 195 - 198 дугаар зүйл</b> 1. Хууль тогтоогчоос Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн аль нэг асуудлыг дахин авч үзэх шаардлагын талаар мэдэгдэл хийх эрхтэй. 2. Ийм мэдэгдлийн дараа хууль ёсоор хоёр танхим тарна. Хоёр танхимыг Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн дагуу шинээр бүрдүүлнэ. 3. Танхимууд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлыг дахин хэлэлцэх шийдвэрийн талаар Хаантай зөвшилцөнө. Энэ тохиолдолд танхим тус бүр гишүүдийн 2/3-ын ирцтэйгээр төслийг хэлэлцэж санал өгсөн гишүүдийн 2/3-оос доошгүйн саналаар нэмэлт, өөрчлөлтийг батална. Шинээр байгуулагдсан танхимууд Үндсэн хуулийн хэсэг, бүлэг, зүйлийн дугаар, дарааллын талаар Хаантай зөвшилцөж, Үндсэн хуулийн франц, герман, нидерланд эх бичвэртэй нийцүүлнэ. Энэ тохиолдолд танхим тус бүр гишүүдийн 2/3-ын ирцтэйгээр өөрчлөлтийг нийцүүлэх шийдвэрийг хэлэлцэн санал өгсөн гишүүдийн 2/3-оос доошгүйн саналаар батална.</p>	<p><b>196, 197 дугаар зүйл</b> Дайны цагт, эсхүл Холбооны нутаг дэвсгэр дээр хоёр танхим чөлөөтэй цугларах боломжгүй үед Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй. Хаан ширээнд хааныг түр орлож буй тохиолдолд Хааны Үндсэн хуулийн бүрэн эрхийн асуудлаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй.</p>

<p><b>ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ</b></p>	<p><b>Статья 195</b> Законодательная власть имеет право заявить о необходимости пересмотра того или иного указанного ею конституционного положения.</p> <p>После этого заявления обе палаты распускаются по полному праву. Новые палаты созываются в соответствии со <a href="#">статьей 46</a>.</p> <p>Эти палаты принимают в общем согласии с Королем решение о положениях, подлежащих пересмотру.</p> <p>В этом случае палаты могут вести обсуждение в присутствии не менее двух третей членов каждой из них; никакое изменение не может быть принято, если оно не соберет по меньшей мере двух третей поданных голосов.</p> <p><b>Статья 198</b> В общем согласии с Королем учредительные палаты могут адаптировать нумерацию статей и подразделов статей Конституции, а также структурирование Конституции по частям, главам и разделам, изменять терминологию положений, не подлежащих пересмотру, для их приведения в соответствие с новыми положениями и обеспечения соответствия между французским, нидерландским и немецким текстами Конституции.</p> <p>В этом случае палаты могут принимать решение в присутствии не менее двух третей членов каждой из них; и изменения будут адаптированы, только если все нововведения в целом соберут не менее двух третей поданных голосов.</p>		<p><b>Статья 196</b> Никакой пересмотр Конституции не может быть начат или продолжен во время войны или в период, когда палаты не могут свободно собраться на федеральной территории.</p> <p><b>Статья 197</b> Во время регентства никакое изменение не может быть внесено в Конституцию в части конституционных полномочий Короля и <a href="#">статьи 85-88, 91-95, 106</a> и <a href="#">107</a> Конституции.</p>
--	--	--	--

\* \* \*



## 10. БЕЛЬГИЙН ВАНТ УЛС /Парламентын монархи/

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
<p>Баталсан: <b>1994.02.17</b> (1996.03.25, 1997.02.28 1997.03.11, 1997.03.20 1998.06.12, 1998.06.17 1998.11.20, 1998.12.11 1999.03.12, 1999.05.07 2000.03.23, 2000.05.16-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан) 9 хэсэг, 8 бүлэг, 198 зүйлтэй</p>	<p><b>195, 198 дугаар зүйл</b> Хууль тогтоогч үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх талаар мэдэгдэл хийх эрхтэй. Хоёр танхимын аль аль нь хэлэлцэн батлах эрхтэй.</p>	<p><b>VIII хэсэг, 195-198 дугаар зүйл</b> 1. Хууль тогтоогчоос Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн аль нэг асуудлыг дахин авч үзэх шаардлагын талаар мэдэгдэл хийх эрхтэй. 2. Ийм мэдэгдлийн дараа хууль ёсоор хоёр танхим тарна. Хоёр танхимыг Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн дагуу шинээр бүрдүүлнэ. 3. Танхимууд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлыг дахин хэлэлцэх шийдвэрийн талаар Хаантай зөвшилцөнө. Энэ тохиолдолд танхим тус бүр гишүүдийн 2/3-ын ирцтэйгээр төслийг хэлэлцэж санал өгсөн гишүүдийн 2/3-оос доошгүйн саналаар нэмэлт, өөрчлөлтийг батална. Шинээр байгуулагдсан танхимууд Үндсэн хуулийн хэсэг, бүлэг, зүйлийн дугаар, дарааллын талаар Хаантай зөвшилцөж, Үндсэн хуулийн франц, герман, нидерланд эх бичвэртэй нийцүүлнэ. Энэ тохиолдолд танхим тус бүр гишүүдийн 2/3-ын ирцтэйгээр өөрчлөлтийг нийцүүлэх шийдвэрийг хэлэлцэн санал өгсөн гишүүдийн 2/3-оос доошгүйн саналаар батална.</p>	<p><b>196, 197 дугаар зүйл</b> Дайны цагт, эсхүл Холбооны нутаг дэвсгэр дээр хоёр танхим чөлөөтэй цуглаарах боломжгүй үед Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй. Хаан ширээнд хааныг түр орлож буй тохиолдолд Хааны Үндсэн хуулийн бүрэн эрхийн асуудлаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй.</p>

<p><b>ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ</b></p>	<p><b>Статья 195</b></p> <p>Законодательная власть имеет право заявить о необходимости пересмотра того или иного указанного ею конституционного положения</p> <p>После этого заявления обе палаты распускаются по полному праву. Новые палаты созываются в соответствии со <a href="#">статьей 46</a>.</p> <p>Эти палаты принимают в общем согласии с Королем решение о положениях, подлежащих пересмотру.</p> <p>В этом случае палаты могут вести обсуждение в присутствии не менее двух третей членов каждой из них; никакое изменение не может быть принято, если оно не соберет по меньшей мере двух третей поданных голосов.</p> <p><b>Статья 198</b></p> <p>В общем согласии с Королем учредительные палаты могут адаптировать нумерацию статей и подразделов статей Конституции, а также структурирование Конституции по частям, главам и разделам, изменять терминологию положений, не подлежащих пересмотру, для их приведения в соответствие с новыми положениями и обеспечения соответствия между французским, нидерландским и немецким текстами Конституции.</p> <p>В этом случае палаты могут принимать решение в присутствии не менее двух третей членов каждой из них; и изменения будут адаптированы, только если все нововведения в целом соберут не менее двух третей поданных голосов.</p>		<p><b>Статья 196</b></p> <p>Никакой пересмотр Конституции не может быть начат или продолжен во время войны или в период, когда палаты не могут свободно собраться на федеральной территории.</p> <p><b>Статья 197</b></p> <p>Во время регентства никакое изменение не может быть внесено в Конституцию в части конституционных полномочий Короля и <a href="#">статьи 85-88, 91-95, 106</a> и <a href="#">107</a> Конституции.</p>
--------------------------------------	---	--	--

\* \* \*

## 11. БҮГД НАЙРАМДАХ ИТАЛИ УЛС /парламентын БНУ/

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
Үүсгэн байгуулах хурлаас <b>1947</b> онд баталсан. 10 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт орсон. 2 хэсэг, 10 бүлэг, 139 зүйлтэй	<b>71 дүгээр зүйл</b> Засгийн газар, хоёр танхим, түүний гишүүн бүр, 50000-аас доошгүй тооны сонгогч, мөн Үндсэн хуулиар эрх олгогдсон бусад байгууллага санаачилна.	<b>138-139 дугаар зүйл, 73-74 дүгээр зүйл</b> Үндсэн хууль болон Үндсэн хуулийн бусад хуулийг өөрчлөх хуулийг Танхим тус бүрээр хэлэлцэн батлах бөгөөд хэлэлцүүлгийн хооронд 3 сараас доошгүй хугацаатай дараалсан хоёр хэлэлцүүлэг явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт Танхим тус бүрийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар батална. Хэрэв баталсан хуулийг нийтэлснээс хойш 3 сарын дотор аль нэг Танхимын гишүүдийн 1/5 нь, эсхүл 50 000 сонгогч, эсхүл 5 мужийн зөвлөл ард нийтийн санал асуулга явуулахыг шаардвал санал асуулгаар хэлэлцүүлж хүчинтэй саналын олонхоор батлагдсанд тооцно. Хоёр дахь хэлэлцүүлгээр Танхим тус бүрт гишүүдийн 2/3-ын саналаар батлагдсан бол ард нийтийн санал асуулга явуулахгүй. Баталсан хуулийг түүнд хугацаа заагаагүй бол Ерөнхийлөгч 1 сарын дотор эцэслэн ёсчилно. Ерөнхийлөгч дахин хэлэлцүүлэхээр буцааж болох ба танхимаас хуулийг хэвээр батлах бол Ерөнхийлөгч дээрх журмын дагуу эцэслэн ёсчилно.	<b>139 дүгээр зүйл</b> Бүгд Найрамдах улсын төрийн удирдлагын хэлбэрийг өөрчлөх асуудлаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
<b>ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ</b>	Статья 71. Законодательная инициатива принадлежит Правительству, любому члену палат, а также тем органам и институтам, которые ею наделены конституционным законом*(14). Народ осуществляет законодательную инициативу путем внесения от имени не менее чем пятидесяти тысяч избирателей законопроекта, составленного в форме статей законопроекта*(15). Статья 138. Законы, изменяющие Конституцию, и другие конституционные законы принимаются каждой из палат после двух последовательных обсуждений с промежутком не менее трех месяцев и одобряются абсолютным большинством членов каждой палаты при втором голосовании. Эти законы выносятся на народный референдум, если в течение трех месяцев после их опубликования этого потребует пятая часть членов одной из палат, или пятьдесят тысяч избирателей, или пять областных советов. Закон, вынесенный на референдум, не считается принятым, если он не одобрен большинством признанных действительными голосов. Референдум не проводится, если при втором голосовании в каждой из палат закон был принят большинством в две трети голосов их членов.		Статья 139. Республиканская форма правления не может быть предметом конституционного пересмотра.

\* \* \*

## 12. ЛЮКСЕМБУРГИЙН ВАНТ УЛС

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
Батлагдсан: <b>1868.10.17</b> 1919 оноос 1995 он хүртэл нэмэлт, өөрчлөлт оруулсан. 11 бүлэг, 122 зүйлтэй	<b>114.1.</b> Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн саналыг хууль тогтоогч зарлан мэдэгдэх эрхтэй.	<b>114 дүгээр зүйл</b> 1. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн саналыг хууль тогтоогч зарлан мэдэгдэх эрхтэй. 2. Мэдэгдлийн дараа Танхим өөрөө тарна. 3. Шинэ танхимыг Үндсэн хуулийн 74 дүгээр зүйлийн дагуу бүрдүүлнэ. 4. Нэмэлт, өөрчлөлтийг дахин авч хэлэлцэх асуудлаар Вантай зөвшөлцсөний үндсэн дээр Танхим шийдвэр гаргана. 5. Энэ тохиолдолд танхим нь гишүүдийн 3/4-аас доошгүйн ирцтэйгээр хуралдаж, гишүүдийн 2/3-ын саналаар батална.	<b>115 дугаар зүйл.</b> Хаан ширээнд Ванг түр орлож буй тохиолдолд Вангийн Үндсэн хуулийн бүрэн эрхийн асуудлаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй.
<b>ЭХ БИЧВЭР, СУРВАЛЖ</b>	(1) Законодательная власть вправе объявить о необходимости пересмотра любого конституционного предписания.	Статья 114 (1) Законодательная власть вправе объявить о необходимости пересмотра любого конституционного предписания. (2) После этого заявления Палата автоматически распускается. (3) Новая Палата собирается в соответствии со <a href="#">статьей 74</a> . (4) Эта Палата принимает решение с согласия Великого Герцога по вопросам, подлежащим пересмотру. (5) В этом случае Палата может заседать только при наличии не менее трех четвертей ее членов, причем никакое изменение не может быть принято иначе как по меньшей мере двумя третями голосов.	Статья 115 В период регентства никакая поправка, касающаяся конституционных прерогатив Великого Герцога, его статуса, а также порядка престолонаследия, не может быть внесена в Конституцию.

\*\*\*

## 13. НИДЕРЛАНДЫН ВАНТ УЛС

Үндсэн хууль баталсан огноо, бүтэц	Санаачлах, боловсруулах, өргөн мэдүүлэх субъект	Хэлэлцэн батлах дэг, журам	Нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, хязгаарлалт, хэлбэр
------------------------------------	---	----------------------------	--



<p>Баталсан: 1983.02.17 8 бүлэг, 142 зүйлтэй Хавсралт 1972 оны Үндсэн хууль</p>	<p>137 дугаар зүйл Хаанаас зөвшөөрөл авсан байна. Парламент санаачлах эрхтэй.</p>	<p>137, 138 дугаар зүйл 1. Үндсэн хуулийг өөрчлөхийн тулд парламентын санал болгосон найруулгаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатайг заасан Актыг парламент гаргах ёстой. 2. Хааны санал болгосноор, эсхүл түүний нэрийн өмнөөс, эсхүл өөрөөр заагдсан журмын дагуу хоёр дахь танхим хуулийн төслийг хэд хэдэн хуулийн төсөл болгон хувааж болно. 3. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан Парламентын Акт нийтлэгдснээс хойш хоёр танхим тарна. 4. Шинээр бүрдсэн хоёр танхим хуулийн төслийг хэлэлцэж 2/3 саналаар батлана. Мөн хэрэв хуулийн төслийг хоёр дугаар хэлэлцүүлгийн дараа Хаан сайшаасан бол хоёр танхимаас тус бүр 2/3-ын саналаар гаргасан Парламентын Актаар дараахийг нэмж болно: 1. Шинээр оруулж буй нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн өөрчлөгдөөгүй заалттай нийцүүлсэн. 2. Нэмэлт, өөрчлөлтийн дагуу дарааллын дугаарыг өөрчилсөн.</p>	<p>139,140,141,142 дугаар зүйл Мужууд баталж, Хаан дэмжсэн нэмэлт, өөрчлөлтүүд нийтлэгдсэн даруйдаа хүчин төгөлдөр үйлчилнэ. Батлагдсан нэмэлт, өөрчлөлттэй зөрчилдөж буй парламентын акт, бусад тогтоомж нь тэдгээрийг Үндсэн хуультай нийцүүлэх хүртэл хүчинтэй хэвээр байна. Үндсэн хуулийн өөрчлөгдсөн заалтын бичвэрийг Хааны зарлигаар нийтэлж, Үндсэн хуулийн бүлэг, хэсэг, зүйлийн дараалалд өөрчлөлт оруулна. Парламентын актаар Үндсэн хуулийн зүйлийг Нидерландын Вант Улсын Тунхаглал (Харти)-тай нийцүүлж болно. Энэ тохиолдолд 139,149, 141 дүгээр зүйлийг нэгэн адил хэрэглэнэ.</p>
---	---	---	--

